



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах,
хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Хотын ногоон байгууламжийн сангийн дүрмийн 3 дугаар бүлгийн 3.1.7, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгийн ногоон байгууламжийг арчлан тордох, мод, сөөг, цэцэг, зүлэг тарих ажлыг агротехнологийн дагуу гүйцэтгэх мэргэжлийн цэцэрлэгчдийг сургаж бэлтгэх ажлын сонгон шалгаруулалтад шалгарсан “Эко Монгол эрдэнэ” Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв /МСҮТ/ -тэй гэрээ байгуулж, хамтран зохион байгуулахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т даалгасугай.

2. Цэцэрлэгчин бэлтгэх сургалтанд шаардагдах хавсралтанд заасан нийт 10.000.000 /Арван сая/ төгрөгийг Нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгийн ногоон байгууламжийн арчилгааны зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

3. Сургалтын хөтөлбөрийн дагуу хичээлийн явц, чанар, үр дүнд хяналт тавьж, суралцагчдыг бүрэн хамруулж, тайлагнаж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/, бэлтгэгдсэн цэцэрлэгчдийг ажлын байраар хангах арга хэмжээ авч ажиллахыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ /Б.Бямбадорж/-д тус тус үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  С.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 02 сарын 20
өдрийн 138 тушаалын хавсралт



ЦЭЦЭРЛЭГЧИН БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ЗАРДАЛ

Д.Д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгж өртөг /төгрөг/	Нийт зардал /төгрөг/
1.	Багшийн цалин	14хоног х 8 цаг = 112 цаг	10000	1.120.000
2.	Туслах ажилтан лаборантын цалин	14 хоног х 8цаг =112 цаг	8000	887.000
3.	Унаа, хоолны зардал	50 хүн х 14 хоног	4000	2.800.000
4.	НДШимтгэл АО 12%	50хүн		168.000
5.	Бичиг хэргийн зардал	14 хоног	21500	1.075.000
6.	Хичээлийн танхим, үзүүлэн, техник хэрэгслийн зардал		130.000	1.820.000
7.	Анонс	2 ширхэг	65.000	130.000
8.	Дадлагын автобусны хөлс	1автобус х 4 өдөр	500.000	2.000.000
	ДҮН /төгрөг/			10.000.000